

## Баялаг ба ядуурлын тухай

*С.Баатар, Эдийн засгийн ухааны доктор PhD, профессор*

Ядуурлын тухай ойлголт хувийн өмч, зах зээлтэй зэрэгцэн яригдаж, хүн төрөлхтөний түүхийн туршид байсан билээ. Юуг ядуурал гэх талаар маргаан, мэтгэлцээн зөндөө байдаг. Манай монголчууд ч үүнээс ангид байгаагүй. Нээлттэй нийгэм, зах зээлийн тогтолцоонд орсноос хойшхи хорь шахам жилд ярьдаг зүйлийн нэг нь байлаа.

Ер нь ядуурлыг ойлгохын тулд “баялаг” гэдэг утгын мөн чанар, төрөл, чиглэлийг сайн ойлговоос зохилтой. Учир нь *баялаг хомсдохыг ядуурал* гэдэг. Тэгвэл баялгийг хүн төрөлхтөний түүхийн явцад онолын сэтгэлгээнд ч, практик амьдралд ч агуулга талаас янз бүрийн өнцгөөс тайлбарлаж ирсэн. Баялаг ба түүний уг сурвалжийг физиократууд газар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй, маркантистууд худалдаа хийх, алт, мөнгө хуримтлуулахтай голдуу холбож байсан бол марксистууд хөдөлмөртэй холбож байлаа.

Эд бүгдийн цаана тухайн үедээ байр, суурь нь бэхжиж байсан тодорхой анги, давхарга байдаг. Эдгээр нь бүгд харьцангуй үнэний хувьтай. Хөгжлийн явцад агуулга нь өөрчлөгдсөөр ирсэн ч мөн чанар нь гэвэл *баялаг болбоос “үргэлж хөдөлгөөнд байж орлого, үр өгөөж авчирч чадах”* биет ба биет бус бүх капиталыг ойлгодог. Монголчуудын ахуйн сэтгэлгээнд ч баялгийн талаар өдий төдий зүйр цэцэн үг бий. Жишээлбэл: эрдэм ном (оюунлаг хүчин зүйл) эрхэм баян, үр хүүхэд (ирээдүйн хөдөлмөр) дунд баян, эд хөрөнгө (алт, мөнгө г.м) адгийн баян гэсэн байдаг. Гэхдээ зах зээл эрчимжсэн өнөө үеийн ойлголтоос арай өөр нь гэвэл статик байдалд байгаа хадгалсан, нөөцөлсөн зүйлийг тухайн нөхцөл байдалд тохируулан баялаг гэж үзэж байсан бол өнөө үед орлогыг тасралтгүй өсгөж, нийгмийн харилцааны хүрээнд эргэлтэнд орж чадах юмыг баялаг гэж ойлгох нь жинхэнэ бизнес сэтгэлгээ

юм. Ядахдаа үнэлэмжийх нь ханш цагийн явцад буурахгүй зүйл байх хэрэгтэй байдаг.

Баялаг гэдэг нийгэм ба хувь хүний бодит хэрэгцээг хангаж, тэдний оршин байх арга, хөгжилд нэмэр тус болох аливаа ашигт чанарыг хэлнэ гэж товчоор илэрхийлж болно.

Дэлхий нийтийн өнөөгийн өндөрлөгөөс харахад баялгийг гурван гол төрөлд хуваан үзэж болно. Энэ нь:

- Уламжлалт ойлголт болсон **эд, оюуны баялаг**,
- Хүмүүнлэг ёс, хүний эрхийн үүднээс яригдах **нийгэмшсэн (социал) баялаг**,
- Дэлхий нийгмийн өнөөгийн гол дүр зураг болж чухалчлагдаж буй **харилцааны баялаг** юм.

Янз бүрийн улс оронд эдгээр гурван баялаг түүхэн өөр өөр үед харилцан адилгүй байр суурьтай байж, бас тэдгээрийн өөр хоорондын хамаарал, харилцан нөхцөлдөх чадвар, үр нөлөө нь тус тусдаа жигд бус байдаг. Үүнээс үүдээд дээрх гурван баялаг хомсдоноос гурван төрлийн ядуурал байдгийг хүлээн зөвшөөрөх ёстой болдог.

Бид хамгийн ойлгомжтой, уламжлалт сэтгэлгээний хүрээндэд материалын баялаг өмсөх эдлэх, идэх уух хэрэгцээнийхээ хүрээнд л маргаж, төр засгийн бодлого ч ихэвчлэн ийм ядууралтай “дайн” зарладаг. Манай улсын хувьд дээрх баялагууд бүгд хомсдолд байгаа. Эл баялагууд хүрэлцээтэй болж, үр дүнгээ өгөх үед хөгжил ирэх учиртай. Эдгээрийг арай дэлгэрүүлэе.

Эд, оюуны баялаг гэдэгт биежиж материалжсан эд юмс, (мал, газар, машин, хувцас, хоол унд, г.м). Түүнчлэн материалжсан мэдлэг (техник, технологи,

арга ажиллагаа) хэмээх оюунлаг зүйлс орно.

Түүхээс үзвэл анхны хуримтлалыг хүчирхийллээр бий болгож чадсан эзэн орнууд нэгэнт санаачлагыг гартаа авч, үүнийг хийж амжсан. Энэ нь XVII зуунаас эхлэн аж үйлдвэрийн хувьсгалтай нийлээд хөгжил дэвшлийг авчирсан нь үнэн. Бас ядуучуудын давхаргыг бий болгож, пролетари гэгдэх үгээгүйчүүдийн армийг төрүүлсэн билээ. Улмаар ангич бодлогын эрс тэс тэмцэлд хүргэсэн. Баяжилт, ядуурал хоёр зүгээр нэг хүмүүс хоорондын бус, үндэстэн хоорондын асуудал болж колоничлол үүссэн. Энэ бүхэн нь эрх чөлөө, бие даалт зэрэг бусад социал (нийгэмшсэн) олон асуудлыг босгож ирэхэд хүргэсэн. Улмаар Октябрийн хувьсгал болон дэлхийн хоёр удаагийн дайн болжээ. Жирийн хүмүүс ядуу ч гэсэн адилхан амьдрах, эрүүл энх, боловсролтой байх зэрэг өөрт ойлгомжтой эрмэлзэл рүү хөтлөгджээ.

Сүүлдээ хүйтэн дайны үе эхэлсэн бөгөөд энэ нь их гүрнүүдийн стратегийн амбиц, тэдний удирдлагуудын шийдэл зэргээс болж янз бүрийн өнгө аястайгаар, бага буурай орнуудыг бас хоёр талд хуваасан аж.

Харин энд эд, оюуны баялагийг шүтсэн капиталист гэгдэх систем хэдийгээр хуучин маягийн колони хараат орнуудаа бүхэлд нь алдсан ч гэсэн олон ургалч үзлийг ашиглаж чадсны ачаар нийгэмшсэн (социал) баялгийг социализмаас ч суралцаж, өөрөө ч бий болгож, 1990-ээд оны их давалгааны үед ялалт хийж чадсан болно. Тэгвэл нийгэмшсэн (социал) баялаг гэдэг юу вэ? Хамгийн товчоор энэ нь хүний хөгжлийн асуудал, тухайлбал боловсрол, эрүүл мэнд, хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт бөгөөд тэдгээр нь эргээд эзэндээ өгөөж өгч чадах боломжтой байхыг ойлгоно.

Социализм энэ талаар “дажгүй” байсан боловч эргэх холбоо нь муу, дэвшил хөгжлийг үзэл суртлаар боймолсон билээ. Хариу өгөөж нь эд, оюуны баялагтайгаа авцалдаж чадахгүй байсан. Түүгээр ч барахгүй социалист системийнхэн капиталист зах зээлийн орнуудын эд, оюуны баялаг бүтээх давуу талыг ойлгож ашиглахыг огт хүсэлгүй, юм бүрийг нь туйлшран муучилж байсан. Эцэстээ эдийн засаг нь социал бодлогынхоо бодит үндсийг бий болгож чадалгүй нурсан билээ. Аливаа юманд зохистой бүтэц нийцтэй түвшин гэж байх ёстойн нэг жишээ энэ юм. Капиталист зах зээлийн нийгэм анхнаасаа аваад бас нэг их диваажин биш байсан учир түүхэнд өөрийнхөө муугаас болж социалист систем үүсгэхэд хүргэсэн нь мэдээж.

Аливаа улс орон хөгжих гэж, ингэхийн тулд баялаг бүтээх гэж эрмэлздэг нь зүй. Гэвч баялгийн дээр өгүүлсэн анхдагч, хоёрдогч төрлүүд сүйдтэй бий болж чадаагүй орнуудад (тэр тоонд Монгол орно) гуравдагч төрөл болох харилцааны баялаг бүтээхэд хямдгүй. Гэхдээ эд, оюуны болон социал баялаг, харилцааны баялгийг зэрэг бүтээх зорилт тавихаас өөр аргагүй юм.

Дэлхийн хөгжлийн хандлагаас үзэхэд XXI зуунд капитал баялаг ба социал (нийгэмшсэн) баялагтаа тулгуурлаж, харилцааны баялагийг ашиглан улс орон оршин тогтнох боломж харагдаж байна.

Харилцааны баялагт юу хамаарах вэ? Энэ нь тусгаар тогтнол, сайн засаглал, тэгш шударга хуваарилалт, хуулийн болон ёс суртахууны зохист хэм хэмжээ, эрх ба хариуцлагын зөв тэнцвэр, улс орон ч, хувь хүн ч ялгаагүй бусадтай эн тэнцүү аль болох өргөн хүрээнд бүх талаар харилцах чадамж, үйлчилж, үйлчлүүлэх урлаг, ёс зүйн хэм хэмжээ, өөрөө эрх эдлэхийн зэрэгцээ бусдын эрхийн төлөө хүлээх хариуцлага зэргийг багтаана. Монгол улс дээр дурдсан гурван төрлийн баягийн аль алинаар ядуу байгааг бид

хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Тухайлбал, нийт үйлдвэрлэлийн дотор эцсийн боловсруулалтад хүрсэн хэсэг нь тун чамлалтай хувийг эзлэх бөгөөд нэг хүнд ногдох ДНБ нь 1000 ам.доллар орчимд эргэлдэж, дэлхийд ядуу буурай орны тоонд орж байна. Техник-технологийн өөрийн гэсэн ололт хомс, гадны патентийн эрх мэдэлд байна. Хөгжлийн илрэл болсон шинжлэх ухаан, технологийн үндэсний ололт бүтээл харьцангуй бага байна. Энэ бүхэн нь эд, оюуны баялгаар ядууралд байгааг илтгэнэ. Эдгээр сул талаа ч бид сайн ойлгодог.

Дэлхийн дундажтай жишихэд монголын хүн амын маш цөөн хэсэг нь амьжиргаагаараа зохих түвшинд дүйцэж, нэлэнхүйдээ ядуу байна. Хүн амын 30-40 хувь нь ядуу гэх албан ёсны нэг түвшин ярьдаг боловч үнэлэх хэмжүүрийг тооцдог амьжиргааны доод түвшин гэдэг ойлголт өөрөө бас үлэмж бага түвшинд тогтоогдсон байдаг.

Социал (нийгэмшсэн) баялгийн хувьд тус улс социализмын үед эдийн засгийнхаа хөгжлийг тодорхой хэмжээнд барьж, энгийн нөхөн үйлдвэрлэл арай чамай явуулж байсны хүчинд эрүүл мэнд, соёл, боловсрол харьцангуй сайн хөгжсөн билээ. Гэвч эргээд үр өгөөжөө тэр бүр өгдөггүй боловсрол байсан. Өнөөдөр ч гэсэн тэр инерци үргэлжилж яваа. Монгол улс арван мянган хүнд ногдох эмч, суралцагсдын тоо гэх мэтээрээ олон улсын дунджаас дээгүүр орох боловч монгол хүний дундаж наслалт, эрүүл мэнд тааруу, бүх нийтийн боловсрол өмнөх үеэс буураад байгаа зэргээр бид социал (нийгэмшсэн) баялгаар ядууралд байна.

Харилцааны баялгийн тухайд шинэ нөхцөл байдалд зохистой хэм хэмжээг барьж чадвал үр дүн өгнө. Харилцааны баялаг бол материаллаг үндсийнхээ хувьд зах зээлийн нөхцөлд татвартай нягт холбоотой. Учир нь төр олон төрлийн татварыг авахдаа нийгмийн харилцааг зөв

зохицуулахад зорих ёстой байдаг. Хэнээс, ямар хэмжээтэй татвар авч, хэзээ, хэнд, юунд дахин хуваарилах, төр засаг өөрөө ямар дэг горимоор оршин тогтнох, улс орныхоо дотоод, гадаад бодлогын хэм хэмжээг зөв авч явах, зохистой хууль, дүрмийг нийгэмд үйлчлүүлэх, ёс зүй, соёлт байдлыг дэмжих зэрэг харилцааны олон асуудлыг зохицуулах үүрэгтэй. Хүнд суртал, нүсэр аппаратгүй, авилгал, хахуулийг хязгаарласан бүх үйлдэл бол чухамдаа харилцааны баялаг юм. Гэтэл өнөөгийн бидний энэ талаарх бодит түвшин ямар байгааг нуршилтгүй тодорхой.

Адгийн наад зах нь ардчилал гэдэг үгийг бүрэн утгаар ойлгоогүйгээс гагцхүү эрх чөлөөний талыг илүү дөвийлгөж, хариуцлага тал орхигдсон. Энэ нь мөнгөний ноёрхол тогтоход хүргэж байгаа юм. Шинэ үеийн иргэд үүнд хэт автаж, хүмүүнлэг, иргэнлэг шинжийг ойшоохгүй байхад хүргэж байна. Бидний эд, оюуны болон нийгэмшсэн (социал) баялаг, харилцааны баялгийн аль аль нь хомс, тэдгээр нь бие биесийг харилцан нөхцөлдүүлж чадаагүй учир бүх талаар ядууралтай байна.

Төр засаг өөрийн бодлогодоо дээрх гурван баялгийг цогц шинжтэйгээр өсгөх, тэдгээрийн нөхөн үйлдвэрлэлийг өргөтгөн гүнзгийрүүлсэн агуулгаар зэрэг хэрэгжүүлэх ёстой.

Баялгийн талаарх нийгмийн үнэлэмжийн стандарт бий болговол зохилтой гэж санагдана. Энэ нь нийгэм, хамт олон, хувь хүн бүрийн эрх ашигт зохицох, шууд утгаараа сайн үр өгөөжтэй байгаагаар нь баялгийг үнэлэмжлэнэ гэсэн үг. Энэ үнэлэмжийн шалгуур нь хүний хөгжлийн цогц үзүүлэлтээр илэрдэг гэж хэлж болно.

“Монгол улсын хүний хөгжлийн илтгэл” хэд хэдэн удаа гарч тухайн нөхцөл байдал тодорхой чиглэлээр бичигддэг. Энд хамгийн гол гурван нэгдмэл үзүүлэлтийг

баримталж (нэг хүнд ногдох ДНБ ний хэмжээ, хүн амын дундаж наслалт, бичиг үсгийн боловсрол) судалгаа хийн дүгнэлт, санал гардаг. Хамгийн гол нь цаашдаа харилцааны баялгаар илрэх хүний хөгжлийн өөр үзүүлэлтийг энд оруулж өгөх талаар эрэл хайгуул хийх шаардлага бий. Тоон үзүүлэлтээр харилцааны баялгийг илэрхийлэх шалгуурыг яаж гаргах вэ? Маш үндэслэлтэй аргачлалаар нэгдмэл шалгуурт оруулах загвар гарган, харилцааны түвшинг илэрхийлэх үзүүлэлт зохиох нь чухал юм.

Ерөнхий чиглэл агуулгыг дурдвал: нийгмийн хэв журмын жирийн зөрчлөөс эхлээд эрүүгийн, захиргааны, иргэний хэрэг гэх мэт хууль зөрчсөн бүх тохиолдолд мэргэжлийн үнэлгээ өгч (зөрчил бүрээр тогтоож болох тодорхой итгэлцүүрээр), нэг хэмжүүрт оруулан, нийгмийн хууль ёсны харилцааны шалгуур үзүүлэлтүүдийн нэгж гаргаж аваад, нийт дүнгээ 10.000 хүнд ногдуулж тооцон өсөлт, бууралтыг цэгнэж дүгнэдэг практик бий болговол зохилтой.

Уг үзүүлэлтүүдээ цаг хугацаа, улс орнуудаар харьцуулан жишиж, хүмүүнлэг, иргэнлэг харилцааны түвшинг харуулж болно. Ийм үзүүлэлт бий болгохдоо судалгаа шинжилгээ хийж, ярилцаж тогтоох хэрэгтэй.

Хүний хөгжлийн шалгуур хэмээгдэх наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох ДНБ гуравт нийгмийн боловсронгуй харилцааг илэрхийлэх бүрэн цогц утга тусч хараахан чадахгүй байгаа дутмаг талыг нөхөн гүйцээхэд дээрх үзүүлэлтийг оруулснаар зохих үр дүн өгөх юм.